



СТАТИСТИКЧ ИХ, БАГА ЭМЧ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДАХ АЖИЛТАНД МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

Улаанбаатар хот

2012 оны 3 дугаар сарын 5

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь статистикч их, бага эмч, нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн удирдах ажилтанд мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааг “Эрүүл мэндийн тухай” хууль болон Монгол улсын Эрүүл мэндийн сайд, Боловсрол соёл, Шинжлэх ухааны сайдын хамтарсан 408/500 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу зохицуулахад оршино.

1.2. Энэхүү мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагаа нь статистикч их, бага эмч, нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн удирдах ажилтны мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, үнэлэх, баталгаажуулахад чиглэгдэнэ.

1.3. “Эмнэлгийн мэргэжилтэн” гэж Эрүүл мэндийн тухай Монгол улсын хуулийн 3.1.5-д заасанчлан хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтныг хэлнэ.

1.4. Ажил үйлчилгээний мэргэжлийн болон чанарын шаардлагыг бүрэн хангасныг болон хандлага, харилцаа, ёс зүйн хувьд тэнцэх эсэх талаар байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар оруулж дэмжсэн нөхцөлд эмнэлгийн мэргэжилтэн өөрийн хүсэлтээр мэргэжлийн зэрэг горилж хүсэлт гаргаж болно.

1.5. Мэргэжлийн зэрэг нь ахлах, тэргүүлэх гэсэн 2 шатлалтай бөгөөд зэргийг шатлал алгасуулан олгохгүй.

1.6. Мэргэжлийн зэргийн шатлал ахиулах хоорондох хугацаа 5-с доошгүй жил байна.

Хоёр. Мэргэжлийн зэрэг олгох шалгуур

2.1. Статистикч их, бага эмч, нийгмийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн удирдлагаар ахлах, тэргүүлэх зэрэг олгоход дараах нийтлэг шалгуурыг баримтална. Үүнд:

- 2.1.1. Мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх,
- 2.1.2. Мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх,
- 2.1.2 Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх.

2.3. Статистикч их, бага эмч, нийгмийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн удирдлагаар ахлах, тэргүүлэх зэрэг олгоход дараах тусгай шалгуурыг баримтална. Үүнд:

2.3.1. "Статистикч их эмчийн ахлах" зэрэг
2.3.1.1. Ахлах зэрэг горилогч эмч нь ажилласан сүүлийн 5 жилийн тайлангаа хамт олны хурлаар хэлэлцүүлж, тайлангаа хурлын протоколтой ирүүлнэ.
2.3.1.2. Статистикч их эмчийн ахлах зэрэг горилохыг ажиллаж буй байгууллага нь зөвшөөрч ажил байдлын тодорхойлолт олгосон байна. Үүнд: Статистикч их эмчийн үйл ажиллагаатай холбоотой доголдол, тайлан мэдээний зөрөө, хугацааны хоцрогдол гаргаагүй талаар тайланг хүлээн авдаг байгууллагын даргын гарын үсэг бүхий албан тодорхойлолт
2.3.1.3. Ахлах зэрэг горилогч эмч нь ажилласан хугацаандаа эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргалгүй ажиллаж, байгууллагын соёл, дотоод дэг журам зөрчөөгүй талаар чанарын хяналтын менежерээсээ авсан ажил байдлын дүгнэлттэй байна.
2.3.1.4. Статистикч их эмчийн мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байна.
2.3.1.5. Ахлах зэрэг горилогч эмч нь сүүлийн 5 жилийн хугацаанд статистикч эмчийн мэргэжлээрээ 3 багц цаг бүхий сургалт, семинарт заавал хамрагдсан байх ба суралцсан сертификатын хуулбаруудыг нотариатаар баталгаажуулсан байна.
2.3.1.6. Ахлах зэрэг горилогч эмч нь өөрийн ажиллаж буй байгууллагын статистик тоо мэдээнд хийсэн дүн шинжилгээ, хамарч үйлчилж буй хүн амын өвчлөл, нас баралтын зонхилж буй шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх талаар хийсэн судалгааны ажлын тайланг 2 жил тутамд тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагад танилцуулсан танилцуулгыг хүлээн авсан тухай албан бичгийн хуулбар.
2.3.2. "Статистикч их эмчийн тэргүүлэх" зэрэг
2.3.2.1. Тэргүүлэх зэрэг горилогч эмч нь статистикч эмчийн мэргэжил дээшлүүлэх 6 сарын ба түүнээс дээш сарын сургалтанд хамрагдсан эсвэл анагаах ухаан, НЭМ-ийн магистрын зэрэг хамгаалсан байна.
2.3.2.2 Тэргүүлэх зэрэг горилогч эмч нь мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, статистикч эмчийн ахлах зэрэгтэй, ахлах зэрэг хамгаалаад 5-аас доошгүй жил ажилласан байна,
2.2.3. Тэргүүлэх зэрэг горилогч эмч нь ажилласан сүүлийн 5 жилийн тайлангаа нэгтгэн, хамт олны хурлаар хэлэлцүүлж, тайлангаа хурлын протоколтой ирүүлнэ.
2.3.2.4. Статистикч их эмчийн тэргүүлэх зэрэг горилохыг ажиллаж буй байгууллага нь зөвшөөрч ажил байдлын тодорхойлолт олгосон байна. Үүнд: Статистикч их эмчийн үйл ажиллагаатай холбоотой доголдол, тайлан мэдээний зөрөө, хугацааны хоцрогдол гаргаагүй талаар тайланг хүлээн авдаг байгууллагын даргын гарын үсэг бүхий албан тодорхойлолт.
2.3.2.5. Тэргүүлэх зэрэг горилогч эмч нь ажилласан хугацаандаа эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргалгүй ажиллаж, байгууллагын соёл, дотоод дэг журам зөрчөөгүй чанарын хяналтын менежерээсээ авсан ажил байдлын дүгнэлттэй байна.
2.3.2.6. Тэргүүлэх зэрэг горилогч эмч нь сүүлийн 5 жилийн хугацаанд статистикч эмчийн мэргэжлээрээ 3-5 багц цаг бүхий мэргэжил дээшлүүлэх сургалтанд заавал хамрагдсан байх ба суралцсан сертификатын хуулбаруудыг нотариатаар баталгаажуулсан байна.
2.3.2.7. Тэргүүлэх зэрэг горилогч эмч нь өөрийн ажиллаж буй байгууллагын статистик тоо мэдээнд хийсэн дүн шинжилгээ, хамарч үйлчилж буй хүн амын өвчлөл, нас баралтын зонхилж буй шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх талаар хийсэн судалгааны ажлын тайланг 2 жил тутамд тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагад танилцуулсан танилцуулгыг хүлээн

авсан тухай албан бичгийн хуулбар.
2.3.4. “Статистикч бага эмчийн ахлах” зэрэг
2.3.4.1. Ахлах зэрэг горилочг бага эмч нь ажилласан сүүлийн 5 жилийн тайлангаа хамт олны хурлаар хэлэлцүүлж, тайлангаа хурлын протоколтой ирүүлнэ.
2.3.4.2. Статистикч бага эмчийн ахлах зэрэг горилохыг ажиллаж буй байгууллага нь зөвшөөрч ажил байдлын тодорхойлолт олгосон байна. Үүнд: Статистикч бага эмчийн үйл ажиллагаатай холбоотой доголдол, тайлан мэдээний зөрөө, хугацааны хоцрогдол гаргаагүй талаар тайланг хүлээн авдаг байгууллагын даргын гарын үсэг бүхий албан тодорхойлолт.
2.3.4.3. Ахлах зэрэг горилочг статистикч бага эмч нь ажилласан хугацаандаа эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргалгүй ажиллаж, байгууллагын соёл, дотоод дэг журам зөрчөөгүй чанарын хяналтын менежерээсээ авсан ажил байдлын дүгнэлттэй байна.
2.3.4.4. Статистикч бага эмчийн мэргэжлийн үнэмлэхийг нотариатаар баталгаажуулсан байна.
2.3.4.5. Ахлах зэрэг горилочг бага эмч нь сүүлийн 5 жилийн хугацаанд статистикч эмчийн мэргэжлээрээ 3 багц цаг бүхий сургалт, семинарт заавал хамрагдсан байх ба суралцсан сертификатын хуулбаруудыг нотариатаар баталгаажуулсан байна.
2.3.5. “Статистикч бага эмчийн тэргүүлэх” зэрэг
2.3.5.1. Тэргүүлэх зэрэг горилочг эмч нь ажилласан сүүлийн 5 жилийн тайлангаа хамт олны хурлаар хэлэлцүүлж, тайлангаа хурлын протоколтой ирүүлнэ.
2.3.5.2. Статистикч бага эмчийн тэргүүлэх зэрэг горилохыг ажиллаж буй байгууллага нь зөвшөөрч ажил байдлын тодорхойлолт олгосон байна. Үүнд: Статистикч бага эмчийн үйл ажиллагаатай холбоотой доголдол, тайлан мэдээний зөрөө, хугацааны хоцрогдол гаргаагүй талаар тайланг хүлээн авдаг байгууллагын даргын гарын үсэг бүхий албан тодорхойлолт.
2.3.5.3. Тэргүүлэх зэрэг горилочг бага эмч нь ажилласан хугацаандаа эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргалгүй ажиллаж, байгууллагын соёл, дотоод дэг журам зөрчөөгүй чанарын хяналтын менежерээсээ авсан ажил байдлын дүгнэлттэй байна.
2.3.5.4. Статистикч бага мэргэжлийн болон ахлах зэргийн үнэмлэхийг нотариатаар баталгаажуулсан байна,
2.3.5.5. Тэргүүлэх зэрэг горилочг бага эмч нь сүүлийн 5 жилийн хугацаанд статистикч бага эмчийн мэргэжлээрээ 3-5 багц цаг бүхий сургалт, семинарт заавал хамрагдсан байх ба суралцсан сертификатын хуулбаруудыг нотариатаар баталгаажуулсан байна,
2.3.7. "Нийгмийн эрүүл мэндийн ажилтны ахлах" зэрэг
2.3.7.1. Ахлах зэрэг горилочг нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь ажилласан сүүлийн 5 жилийн тайлангаа хамт олны хурлаар хэлэлцүүлж, тайлангаа хурлын протоколтой ирүүлнэ.
2.3.7.2. Нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь ахлах зэрэг горилохыг ажиллаж буй байгууллага нь зөвшөөрч ажил байдлын тодорхойлолт олгосон байна,
2.3.7.3. Ахлах зэрэг горилочг нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь ажилласан хугацаандаа эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргалгүй ажиллаж, байгууллагын соёл, дотоод дэг журам зөрчөөгүй чанарын хяналтын менежерээсээ авсан ажил байдлын дүгнэлттэй байна,
2.3.7.4. Нийгмийн эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн үнэмлэхийг нотариатаар баталгаажуулсан байна
2.3.7.5. Ахлах зэрэг горилочг нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь сүүлийн 5 жилийн хугацаанд нийгмийн эрүүл мэндийн мэргэжлээрээ 3 багц цаг бүхий мэргэжил дээшлүүлэх сургалтанд заавал хамрагдсан байх ба суралцсан сертификатын хуулбаруудыг нотариатаар баталгаажуулсан байна.
2.3.8. "Нийгмийн эрүүл мэндийн ажилтны тэргүүлэх" зэрэг
2.3.8.1. Тэргүүлэх зэрэг горилочг нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь мэргэжил дээшлүүлэх 6 сарын ба түүнээс дээш сарын сургалтанд хамрагдсан эсвэл анагаах ухаан, НЭМ-ийн магистрын зэрэг хамгаалсан байна,
2.3.8.2 Тэргүүлэх зэрэг горилочг нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, нийгмийн эрүүл мэндийн ажилтны ахлах зэрэгтэй, ахлах зэрэг хамгаалаад 5-аас доошгүй жил ажилласан байна,
2.3.8.3. Тэргүүлэх зэрэг горилочг нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь ажилласан сүүлийн 5 жилийн тайлангаа хамт олны хурлаар хэлэлцүүлж, тайлангаа хурлын протоколтой ирүүлнэ.
2.3.8.4. Нийгмийн эрүүл мэндийн ажилтны тэргүүлэх зэрэг горилохыг ажиллаж буй байгууллага нь зөвшөөрч ажил байдлын тодорхойлолт олгосон байна,
2.3.8.5. Тэргүүлэх зэрэг горилочг нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь ажилласан хугацаандаа

- удирдах ажилтны мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэхийн баталгаажуулсан хуулбар
- 3.5. Мэргэжлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол үнэмлэхний баталгаажуулсан хуулбар
- 3.6. Нотариатаар баталгаажсан иргэний үнэмлэхний хувь
- 3.7. 3x4 хэмжээний зураг 2 хувь
- 3.8. Мэргэжлийн зэрэг горилогч мэргэжилтний материал тэнцсэн тохиолдолд төлбөрийг дансаар хийсэн байна.

Дөрөв. Мэргэжлийн зэргийн шалгаруулалт зохион байгуулах эрх бүхий Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэгийн чиг үүрэг

- 4.1. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг нь эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох шалгалтын талаар эмнэлгийн байгууллагад мэдээлнэ.
- 4.2. Тусгай шалгуурт шаардлагатай гэж үзвэл өөрчлөлт оруулж болно.
- 4.3. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тухайн чиглэлийн мэргэжлийн зэргийн шалгаруулалтын тусгай шалгуур үзүүлэлт, өөрийн байгууллагын байрлал, хаягийг тодорхой мэдээлнэ.
- 4.4. Мэргэжлийн зэрэг горилогчийн материалыг хянаж, байгууллагын хүний нөөцийн менежерээс чирэгдэлгүйгээр 2012 оны 3 дугаар сарын 19-ний 17 цаг хүртэл хүлээн авна.
- 4.5. Эрүүл мэндийн байгууллагад материал тэнцсэн мэргэжилтний нэрсийг албан тоотоор мэдэгдэнэ.
- 4.6. Шаардлага хангаагүй материалыг тайлбар өгч буцаана.
- 4.7. Шалгалтыг урьдчилан болон хойшлуулж авахыг хориглоно.
- 4.8. Мэргэжлийн зэргийн шалгаруулалтад орох мэргэжилтэнд унших материал, чиглэл, жагсаалтыг гарган мэдээлнэ.
- 4.9. Мэргэжлийн зэрэг горилогчийн материалыг хүлээн авч нягталж шалган, зэрэг олгох шалгаруулалтад орох эмнэлгийн мэргэжилтний жагсаалтыг 3 дугаар сарын 23-ны дотор гарган ЗГХА-Эрүүл Мэндийн Газрын ЭМАССЗХ-т (цаашид зөвлөлийн ажлын алба гэх) хүргүүлнэ.
- 4.10. Мэргэжлийн зэрэг горилж байгаа эмнэлгийн мэргэжилтний мэдээний сан үүсгэж, жил бүр баяжилт хийн ажлын албанд өгнө.
- 4.11. Жил бүр мэргэжлийн зэрэг горилсон болон хамгаалсан мэргэжилтний дүнгийн хуудас, хурлын тэмдэглэлийг Архивын хуулийн дагуу хадгална.
- 4.12. Мэргэжлийн онолын шалгалтын сорилын санг ахлах, тэргүүлэх зэргийн түвшингийн ялгаатайгаар жил болгон шинэчлэн боловсруулж, баяжуулна.
- 4.13. Мэргэжлийн зэрэг олгох комиссын дүнгийн хуудсыг мэргэжилтэн тус бүрээр бөглөн баталгаажуулж, хурлын шийдвэрийн хамт жил бүрийн 5 сарын 22-ний дотор Ажлын албанд ирүүлнэ.
- 4.14. Мэргэжлийн зэрэг олгох тушаалын дагуу мэргэжлийн нийгэмлэг, холбоод мэргэжлийн зэргийн үнэмлэхийг батлагдсан загварын дагуу хэвлүүлэн бичиж, баталгаажсаны дараа холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.
- 4.15. Жил бүр мэргэжлийн зэргийн шалгаруулалтын тайлан, санхүүгийн нэгдсэн тайлан, санал, хүсэлтийг шалгалтын дараа 7 хоногийн дотор ажлын албанд ирүүлнэ.
- 4.16. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг нь зэрэг авсан мэргэжилтний тасралтгүй сургалт, хөгжилд анхаарна.

Formatted: Font color: Auto

Formatted: Font: Not Bold, Font color: Auto

Тав. Мэргэжлийн зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг

- 5.1. Статистикч их, бага эмч, нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн удирдах ажилтан нь нийтлэг болон тусгай шалгуурыг бүрэн хангасан тохиолдолд мэргэжлийн зэргийн шалгаруулалтанд орох эрх үүснэ.
- 5.2. Мэргэжлийн зэргийн шалгалтын талаарх мэдээллээр хангана.
- 5.3. Статистикч их, бага эмч, нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн удирдах ажилтан нь нийтлэг болон тусгай шалгуурын дагуу материалыг баталгаажуулан бүрдүүлж байгууллагын хүний нөөцийн менежерээр дамжуулан хүлээлгэн өгнө.
- 5.4. Бүрдүүлсэн материалын үнэн байдлыг хариуцна.
- 5.5. Тусгай шалгуур болон унших материалын чиглэлийн талаарх мэдээллийг Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгээс авна.
- 5.6. Мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, гомдол гарсан тохиолдолд Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгийн удирдлагад, шаардлагатай гэж үзвэл Салбар зөвлөлд хандана.

Зургаа. Мэргэжлийн зэргийн шалгаруулалт

- 6.1. Мэргэжлийн зэргийн шалгалтанд орох эмнэлгийн мэргэжилтний нэрсийг ЗГХА-ЭМГ-ын даргын шийдвэрээр баталгаажуулан жил бүрийн 4 сарын 15-наас 5 сарын 15-ны хооронд шалгалтыг зохион байгуулна.
- 6.2. Шалгалт нь онолын болон дадлагын гэсэн хоёр хэлбэртэй байх бөгөөд онолын шалгалтыг 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд дадлагын шалгалтанд орно.
- 6.3. Онолын шалгалтыг сорилоор, дадлагын шалгалтыг практик бодлого, ярилцлагын хэлбэрээр авна.
- 6.4. Шалгалтын дүнг комисс онолын шалгалтын дүнг шалгалт дууссанаас хойш 1 цагийн дотор шалгагч машинаар, дадлага шалгалтын дараа шууд дүгнэж мэдээлнэ.
- 6.5. Шалгалтын дүнгийн бодит байдлыг шалгалтын комисс хариуцна.
- 6.6. Зэрэг горилогч нь мэргэжлийн онолын болон дадлагын шалгалтад тус бүр 85 ба түүнээс дээш үнэлэгдсэн нөхцөлд тэнцсэнд тооцно.

Долоо. Мэргэжлийн зэрэг хүчинтэй байх хугацаа, цуцлах, сэргээх

- 7.1. Тухайн мэргэжлээр ажиллаж байгаа бүхий л хугацаанд мэргэжлийн зэрэг хүчин төгөлдөр байна.
- 7.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ зөрчих буюу мэргэжлийн алдаа гаргасан тохиолдолд мэргэжилтний мэргэжлийн зэргийг хүчингүй болно.

Найм. Мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааны санхүүжилт

- 8.1. Мэргэжлийн зэрэг олгохтой холбоотой гарах зардлыг мэргэжлийн зэрэг
горилогч хариуцна.
- 8.2. Зэргийн шалгалтын төлбөр

Formatted: Mongolian (Cyrillic, Mongolia),
Check spelling and grammar

№	Мэргэжил	Хамгаалах зэрэг	Төлбөр ₮
1	Статистикч их эмч	Ахлах	125000₮
		Тэргүүлэх	125000₮
2	Статистикч бага эмч	Ахлах	65000₮
		Тэргүүлэх	65000₮
3	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан Эрүүл мэндийн удирдах ажилтан	Ахлах	125000₮
		Тэргүүлэх	125000₮

Шинэчлэн боловсруулсан:

Н.Нарангэрэл